


# ТОГТВОРТОЙ ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ – ХАА-Н САЛБАРЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ҮНДЭС



**Сайн байна уу? Бидэнд цаг гарган ярилцлага өгч байгаа Танд баярлалаа. Юуны өмнө бидэнд өөрийгөө товч танилцуулна уу?**

Сайн байшгаана уу? Миний нэрийг Алфред Катер гэдэг. Би бага насаа Германы хөдөө тосгонд газар тариалангийн фермд өнгөрүүлсэн. Тухайн үеэс л ХАА-н салбарын хүн болохоор шийдсэндээ. Георг Августын нэрэмжит Гёттинген хотын их сургуулийг агрономч мэргэжлээр төгссөн. Мөн сүүлд энэ сургуульдаа таримал ургамлын өвчин, ургамал хамгааллын чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалах боломж олдсон юм. Эрдмийн зэрэг хамгаалах ажлынхаа хүрээнд би гурван жил Филиппинд ажиллаж, амьдарч, судалгаа хийхийнхээ хажуугаар Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн (ГОУХАН) төсөл дээр ажилласан.

Үүний дараагаар би хөгжлийн хамтын ажиллагааны салбарт хүч сорихоор шийдсэн бөгөөд

одоогийн ажиллаж байгаа ИАК Аграрконсалтинг ХХК-д хорь гаруй жил тасралтгүй ажиллаж байна. Энэ хугацаанд төслийн зохицуулагч, гадаад харилцааны газрын дарга зэрэг албан тушаал хашиж байгаад энэ оны 4-р сараас “Герман-Монголын хамтын ажиллагааны Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн удирдагчаар томилогдон ажиллаж байна.

Манай ИАК Аграрконсалтинг ХХК нь Германдаа төдийгүй олон улсад ХАА-н зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллага бөгөөд бид өнгөрсөн хугацаанд Германы болон олон улсын хандивлагч байгууллагуудын захиалгаар олон төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн. Энэ хугацаад миний бие олон орны ХАА-н салбарын хөгжлийн асуудлуудтай танилсан бөгөөд ялангуяа Азийн орнуудад голлон ажиллаа. Монгол улсыг 2005 оноос илүү сайн мэддэг болсон бөгөөд энэ хугацаанд Европын холбоо, ГОУХАН, ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн

Герман-Монголын хамтын ажиллагааны Тогтвортой Хөдөө аж ахуй төслийн удирдагч  
Др. А. Катер

яам зэрэг байгууллагуудын төсөл, хөтөлбөрүүдийг хариуцан ажиллаж ирлээ.

**Та Тогтвортой хөдөө аж ахуй төслийнхөө талаар манай үншигчдад танилцуулах уу?**

ХБНГУ, Монгол улсын хүнс, хөдөө аж ахуйн салбар дахь хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2012 онд тухайн үеийн Холбооны Хүнс, хөдөө аж ахуй, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах яам, Монгол улсын Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам хамтран “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг хэрэгжүүлэхээр тохиролцсон юм. Төслийн маань эхний үе шат 2013 оны 4-р сараас 2016 оны 3 сар дуустал үргэлжилсэн бөгөөд Монгол орны байгаль, цаг уурын нэхцэлд тохирсон тариалалтын арга туршлагуудыг нэвтрүүлэх зорилготой байсан. Өнгөрсөн оны намар манай 2 яам төслийн хоёрдугаар үе шатыг 2016 оны 4 сараас эхлэн 2018 оныг дуустал хэрэгжүүлэх шийдвэрлэсэн бөгөөд 2 орны ХАА-н хамтын ажиллагааг мэргэжлийн яриа хэлэлцээ хэлбэрээр эрчимжүүлэх чиглэлд түлхүү хамтран



ажиллахаар болсон. Тэгэхээр бидний хувьд Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичгийн хүрээнд дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, Монгол Улсын Засгийн газартай хамтран ажилана. Энэ хүрээнд бид сорт сорилт, үр үргүүлгийн салбарыг сэргээх, тариалангийн салбарт эрсдлийн менежментийг нэвтрүүлэх мөн хөрсний доройтыг багасгах гэсэн гурван үндсэн чиглэлийн дагуу ажилана.

Энэ дашрамд нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд биднийг үргэлж дэмжин, найрсаар хамтран ажиллаж байдаг Монголын түшн байгууллагуудаа маш их талархаж байгаагаа хэлмээр байна. Ялангуяа ХХААХҮЯ биднийг ажиллах нөхцөлөөр хангаж, төслийн үйл ажиллагааг үргэлж дэмждэгт Германы талын хамтрагч байгууллагуудын нэрийн өмнөөс талархсанaa илэрхийлж байна.

**Сорт сорилтын салбарын асуудал манай улсал сүүлийн жилүүдэд нилээд орхигдсон гэж хэлж болно. Та билэнд Герман болон бусад Европын холбооны улсуудад сорт сорилтын салбар хэрхэн ажилладаг талаар сонирхуулаач?**

Үр ашигтай, бүтээмж өндөртэй үр сортын салбар нь өрсөлдөх

чадвартай газар тариалангийн үйлдвэрлэл хөгжүүлэх үндсэн хөрс нь болж өгдөг. Байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон сорт, хүрэлшэхүйц хэмжээтэй сайн чанарын элит үр нь ургацаад шууд нөлөөлдөг юм.

Герман төдийгүй Европын холбооны орнуудад таримлын селекци явуулж, сорт гаргах, үр үргүүлгийн салбар хувийн хэвшлийн нуруун дээр явдаг бол шинэ сортуудыг сорих, баталгаажуулах ажлыг бие даасан хараат бус төрийн байгууллагууд хийж үйцэтгэдэг. Энэ салбар нь бүхэлдээ судалгаа шинжилгээ, инновац дээр тулгуурлан явагдаж байна. Манай улсад үр сортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 130 гаруй аж ахуйн нэгжүүд байдаг ба тэдний 60 гаруй нь өөрийн гэсэн үр үргүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Ихэнх компаниуд нэг таримлаар дагнах биш олон төрлийн таримлын үрийг үргүүлдэг.

Мэдээж шинэ сорт гаргаж авах нь маш их цаг хугацаа хөрөнгө мөнгө шаардсан ажил учир сортыг хамгаалах нь чухал асуудал юм. Сортын хамгаалал нь тус сортыг зохиогчид өөрийнхөө оюуны өмч болох сортыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг нээж, сорт бий болгоход зарцуулсан

өртгөө нөхөх боломж олгодог бөгөөд хамгийн гол нь селекцийн ажилд хувийн хэвшлийг татах гол хөшүүрэг болдог. Харин шинэ сортыг сорих баталгаажуулах ажлыг Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх Холбооны сортын агентлаг хийж үйцэтгэдэг. Сортын баталгаажуулалтын нэгдсэн шалгуурууд нь сортын ялгадах байдал, жигд байдал, тогтвортой байдал, харьшангүй давуу чанар зэргийг шалгаж үздэг. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа сортын үрийг үйлдвэрлэх, зах зээл гаргах зөвшөөрлийг нь өгдөг. Мөн муж бүрээс хамааран янз бүрийн нэмэлт шалгуур үзүүлэлтүүд байх жишээтэй. Хянан баталгаажсан үр сорт гаргаж авах нь маш олон шатлаалыг дамждаг тул зах зээл дээр зөвхөн шалгарсан, бүтээмж өндөртэй сортууд л гардаг.

**Таны харж байгаагаар Монгол улсын үр сортын салбарын үйл ажиллагааг бушааж сэргээхэд хамгийн түрүүнд юу хийх хэрэгтэй вэ?**

Монгол улсад харамсалтай нь 1990-ээд оноос хойш тариалангийн үйлдвэрлэл зах зээлийн системд шилжих явцад сорт сорилтын салбарын бүтэц, зохион байгуулалт алдагдаж, сорт сорилтын бодлого, үрийн



аж ахуйн систем доголдоод байна. Гэхдээ зарим нэгэн эрдэм шинжилгээний байгууллагууд, хувийн аж ахуйн нэгжүүд үр үргжүүлгийн ажлыг үргэлжлүүлэн авч үлдсэн нь их сайшаалтай. Тэгэхээр энэ байгаа бүтэц дээрээ тулгуурлаад энэ салбарыг буцаад хөл дээр нь босгох боломжтой. Үүний тул нэн тэргүүнда хууль эрх зүйн асуудлаасаа эхлэх нь зүйтэй болов уу. Герман улсын хувьд "Үр ашиглах тухай хууль" нь үрийн хянан баталгаажуулалт, төрөл зүйлийн жагсаалт, үрийн чанар, борлуулалт зэрэг асуудлуудыг зохицуулдаг бол "Сорт хамгаалах тухай хууль" нь селекцид, үр үргжүүлэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгддэг.

Хууль эрх зүйн бичиг баримтуудаас гадна Монгол Улсад сорт сорилт, сортын хянан баталгаажуулалт хийдэг бие даасан, хараат бус бүтэц бий болгох зайлшгүй шаардлагатай

гэж харж байна. Тиймээс Монгол орны газар тариалангийн бүсүүдийг төлөөлсөн байршуудад сорт сорилтын салбаруудыг шинээр байгуулах, зарим нэгэн салбаруудын үйл ажиллагааг сэргээх нь сорт сорилтын салбарын хувьд томоохон алхам болох юм. Мөн салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах нь маш чухал асуудал бөгөөд манай төслийн хувьд Холбооны сортын агентлагтай хамтран Дарханы Үргамал, газар тариалангийн хүрээлэн, үр үргжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын мэргэжилтнүүдийг чадавхжуулах чиглэлээр сургалтууд зохион байгуулж, ХХААХҮЯ-нд хууль эрх зүйн орчныг боловсронгүй болгох, бүтэц зохион байгуулалтыг бий болгох тал дээр зөвлөгөө өгч ажиллаж байна.

**Тариалангийн салбарт эрсдлийн менежмент, хөрсний доройтлыг багасгах гэсэн чиглэлүүд ч бас**

#### **манай орны тариалангийн салбарт нэн тулгамдаад байгаа асуудлууд.**

Тиймээ, тариалангийн салбарт эрсдлийн менежментийн системийг нэвтрүүлэх тал дээр бил "Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК-тай хамтран ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр байгалийн гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, өнгөрсөн онд гэхдээ бороо хур хангалтгүй, хэт хуурайшилттай байснаар бил ургацынхаа нилээдгүй хэсгийг алдсан. Тиймээс байгалийн гамшигийн улмаас үйлдвэрлэгчид үүсэх хохирлыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс газар тариалангийн салбарт эрсдлийн менежментийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зарчмаар тариалангийн даатгалын системийг амжилттай



хэрэгжүүлсэн олон орны жишээ байна.

Хөрсний элэгдэл эвдрэлээс хамгаалсан, хөрсөнд ээлтэй технологи нэвтрүүлэх асуудлыг Монгол Улсын Засгийн газар хууль эрх зүйн бичиг баримтууддаа тодорхой зааж өгсөн байдаг. Одоо эдгээр хууль дүрэм, бодлогын бичиг баримтуудыг хэрхэн амьдралд хэрэгжүүлэх вэ гэдэг асуулт үлдээд байна. Эцсийн бүлэгт тариаланч хөрсөнд ээлтэй технологи ашиглаж байна уу, хөрсний үржил шимийг сайжруулах тал дээр юу хийж байна гэдгээс бүх зүйл шалтгаална. Хөрсийг тогтмол шинжилгээнд өгөх, сэлгээнд буурцагт ургамал зэрэг хөрсөнд ээлтэй таримтуудыг тариалах, эрдэст болон органик бордоо ашиглах зэрэг хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах технологийг тариаланч бүр мэддэг, үйл ажиллагаандaa нэвтрүүлдэг байх хэрэгтэй.

**Тэгэхээр танай төслийн хоёрдугаар үе шат эхлээд удаагүй байгаа юм байна. Энэ хооронд юу хийж амжуулав, цаашид ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ?**

Бид түншлэл, эрэлт хэрэгцээнд тулгуурлан төслийнхөө үйл ажиллагааг төлөвлөдөг. Иймд бид нэн тэргүүнэ Монголын түнш байгууллагуудтайгаа хамтран төслийн үйл ажиллагааны төлөвлөлтийн семинар зохион байгуулж, хийх ажлуудаа ач холбогдлын дарааллаар нь эрэмбэлсэн. Энэхүү жагсаалт маань билний цаашины ажилд "хөтөч" болох юм. Дээр дурдсан төслийн үндсэн гурван чиглэлийн хүрээнд бид багагүй ажлыг энэ хугашаанд эхлүүлээд байна. Тухайлбал, сорт сорилт, үрийн аж ахуйн чиглэлээр бид сая 5-р сард ХБНГУ-д салбарын мэргэжилтнүүдийг хамруулсан танилаа аялал, сургалт семинар зохионбайгууллаа. Энэаяллынүеэр манай мэргэжилтнүүд Холбооны сортын агентлаг, сорт сорилтын

салбарууд, үр үржүүлгийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа болон ХБНГУ-ын сорт сорилт, үр үржүүлгийн салбарын өнөөгийн түвшин, цаашины чиг хандлагатай танилцсан, харилцан турслага солилцлоо. Энэ чиглэлээр ажиллаж байгаа мэргэжилтнүүдээ байнгын эргэх холбоотой байлагах үүднээс өнгөрсөн 7-р сард Холбооны сортын агентлагийн газрын дарга Др. Фройденштайн Монгол улсад ирж Дарханы хүрээлэн дээр салбарын мэргэжилтнүүдтэй уулзалт, яриллага хийн, сургалт семинар зохион байгууллаа. Мөн үүнээс гадна бид ХХААХҮЯНД ХАА-н даатгалын тухай хууль боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө өгч байна. Энэ ажлын хүрээнд бид яамтай хамтраад хуулийн төсөлд санал авах хэлэлцүүлгийг энэ намар зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Хөрсний доройтлыг багасгах чиглэлээр олон улсын болон дотоодын эрдэмтэн судлаачдыг оролцуулсан эрдэм шинжилгээний хурлыг ирэх 10 сард зохион байгуулах юм. Мөн манай үйл ажиллагааны бас нэгэн чухал хэсэг нь түнш байгууллагуудаа шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах явдал юм. Бид Монгол орны УХБ, бордооны чиглэлээр зах зээлийн судалгаа хийхээр төлөвлөөд байна.

**Бидэнд шаг гарган яриллага өгсөн Танд баярлалаа. Та бүхний цаашины ажилд өндөр амжилт хүсье!**

Баярлалаа